

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт	Гүйцэтгэлийн хувь
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ							
НЭГ. АЖИЛЛАХ ХҮЧ ИЛГЭЭХ САНАМЖ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ							
Зорилт 1. БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй иргэдийн хөдөлмөрийн гэрээний хэрэгжилтийг хангуулах, хөдөлмөрийн харилцаанд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ							
1.1	БНСУ-д хөдөлмөр эрхэлж буй иргэдэд хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх, орчуулгын үйлчилгээ үзүүлэх		Зөвлөгөө, мэдээлэл өгсөн иргэний тоо: (2500 хүн)	Танхим, утас, цахимаар хандсан 2474 иргэнд хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгч, орчуулгын үйлчилгээ үзүүлсэн.	Зөвлөгөө, мэдээлэл авахаар хандсан иргэн бүрд зөвлөгөө, мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлнэ. (100%)	Тайлант хугацаанд хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгааллын чиглэлээр утсаар 2859, цахимаар 576, танхимаар 335, нийт 3769 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл хүргэн, орчуулгын тусламж үйлчилгээ үзүүлсэн. Хамгийн олон давтамжтай хүргэсэн зөвлөгөө мэдээлэл нь дараах байдалтай байна. Үүнд: - 13 дахь сарын цалин, нутаг буцах зардлын асуудлаар- 323 удаа - Олгогдоогүй цалин хөлсний маргааны асуудлаар- 367 удаа - Орчуулгын үйлчилгээ- 373 удаа - Ажлын байр солих асуудлаар- 225 удаа - Е-7-4 виз руу хөрвүүлэх асуудлаар- 255 удаа - Сэтгэл зүйн зөвлөгөө- 256 удаа - Бусад асуудлаар- 1128 удаа. Хөдөлмөрийн харилцаанд холбогдох 394 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч,	100%

					хуулийн хугацаанд шийдвэрлэн 1,104,493,940 воныг Монгол Улсын иргэдэд олгуулсан. Үүнд: - Олгогдоогүй цалин хөлс- 134,736,267 вон; - Самсунг даатгалын 13 дахь сарын цалин-626,175,029 вон; - Үйлдвэрээс авах 13 дахь сарын цалингийн зөрүү мөнгө- 73,169,560 вон; - Нутаг буцах зардал- 57,983,490 вон; - Үйлдвэрлэлийн ослын даатгалын нөхөн төлбөр- 81,626,430 вон; - Эмнэлгийн төлбөр хөнгөлүүлэх болон бусад- 12,640,000 вон.	
1.2	БНСУ-д оршин суугаа иргэдийн болон гэрээт ажилчдын мэдээллийг холбогдох эх сурвалжаас авч нэгтгэн, мэдээллийн санг шинэчлэх, шаардлагатай статистик, судалгааг тухай бүр гаргах	Мэдээллийн сангийн шинэчлэлт: (жилд 4 удаа) Статистик мэдээ, судалгааг гаргах: (жилд 4 удаа)	Хөдөлмөрийн гэрээт болон БНСУ-д оршин сууж буй иргэдийн тоон мэдээлэл, судалгааг 5 удаа, удирдлага, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу, байгууллагын албан хэрэгцээнд зориулж судалгааг 7 удаа гаргасан.	Мэдээллийн санг шинэчлэн сайжруулна. Статистик мэдээ, судалгааг улирал бүр шинэчилж яам, агентлагт хүргүүлнэ.	Хөдөлмөрийн гэрээт болон БНСУ-д оршин сууж буй иргэдийн тоон мэдээлэл, судалгааг 17 удаа гаргасан. Түүнчлэн гэрээт ажилчдын мэдээллийн сан (19 удаа), өргөдөл гомдлын бүртгэлийн сан (өдөр бүр), сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээний мэдээллийн сан (12 удаа), нутаг буцсан иргэдийн мэдээллийн сан (4 удаа), ур чадвартай ажилчны виз рүү шилжсэн иргэдийн мэдээллийн санг (84 удаа) тухай бүр шинэчлэн баяжуулсан.	100%
1.3	Ур чадвартай ажилчны Е-7-4 визний ангилал руу шилжсэн болон хугацааны болзол хангасан иргэдийн судалгааг шинэчилж, шаардлагатай зөвлөгөө, мэдээллээр хангах	Шинэчилсэн судалгааны тоо: (1) Зөвлөгөө мэдээлэл өгч, үйлчилгээ үзүүлэх иргэний тоо: (200 хүн)	206 иргэнд бүрдүүлэх баримт бичиг, оноо цуглуулах, гэр бүлээ урих, ТОПИК шалгалт болон нийгмийн нэгдсэн хөтөлбөрийн талаар зөвлөгөө өгч, оноо тоолох, орчуулга хийх зэргээр визний ангиллаа солиход нь дэмжлэг үзүүлсэн.	Судалгааг шинэчилж, мэдээлэл авахаар хандсан иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгнө.	Ур чадвартай ажилчны визтэй иргэдийн судалгаа мэдээллийн санг 84 удаа шинэчилж визний ангиллаа сольсон 77 иргэний мэдээлэл, визээ солих хүсэлтэй болон хугацааны болзол хангасан 56 иргэний мэдээллийг бүртгэсэн. Е-7-4 визний асуудлаар 255 иргэнд бүрдүүлэх баримт бичиг, оноо цуглуулах, гэр бүлээ урих, хэлний сургалт, шалгалтад бүртгүүлэх, жолооны үнэмлэх авах, ажлын байр солих, D-10, F-2, E-7-4R, F-2R ангилал руу өөрчлөх зэрэгт мэдээлэл зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн. 10	100%

					иргэний визний ангилал солих, сунгах өргөдлийг шийдвэрлэсэн. Е-7-4 визний асуудлаар мэдээлэл өгөх, эргэх холбоо үүсгэх зорилгоор “Е-7-4 визний мэдээлэл солилцох групп” сошиал группт зорилтот бүлгийн 717 иргэнийг нэгтгэж, 55 удаагийн мэдээлэл, зөвлөгөөг нийтэлсэн. Ур чадвартай ажилчны (Е-7-4) визээр оршин суух тухай гарын авлага (27 хуудас), визний журмын өөрчлөлтийг орчуулан түгээсэн. 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдөр “Гэрээт иргэдийн хөдөлмөрийн харилцаанд тулгарч буй асуудал” сэдэвт цахим уулзалтад “Ур чадвартай ажилчны Е-7-4 виз” сэдвээр 11 иргэнд сургалт мэдээлэл хүргэсэн.	
Зорилт 2. Хөдөлмөрийн гэрээт иргэдийг хууль бусаар оршин суухаас сэргийлэх, хугацаандаа нутаг буцахад шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлэх						
2.1	Хөдөлмөрийн гэрээт ажилчдын ажлын байранд очиж нөхцөл байдалтай нь танилцах, санал хүсэлтийг нь сонсож, хууль бусаар оршин суухын хор уршиг, хугацаандаа нутаг буцах талаар зөвлөгөө, мэдээллийг хүргэх	Очиж ажилласан ажлын байрны тоо: (6 үйлдвэр, ААН) Зөвлөгөө, мэдээлэл өгсөн гэрээт ажилчдын тоо: (100 хүн)	2024 онд Пажү, Тэгү, Нунсан, Тэжон, Игсан, Чежү, Бусан хотын 12 компанийн 134 хөдөлмөрийн гэрээт ажилчны ажлын байранд очиж санал хүсэлтийг нь сонсож, зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.	Гэрээт ажилчдын ажлын байранд улиралд хоёроос доошгүй удаа очиж ажиллана.	Гёнги аймгийн Сон Жинь (주)성진에프씨 үйлдвэрийн 11, Улсан хотын Мёншиниэнжи (주)명신 이엔지 компанийн 1, Кимгённутэг (주)금경이노텍 компанийн 4, Иран (주)일안 компанийн 1, Шихин хотын Дүсанкимсуг (주)두산금속 компанийн 18, Ансан хотын Түдирамфүүд (주)도드람푸드 компанийн 11, Пучон хотын Раун (주)라운 компанийн 10, Жэжү хотын Тушичунхабчолган(주)도시종합철강 компанийн 2 ажилчин, нийт 8 компанийн 47 гэрээт ажилчны ажлын нөхцөл байдалтай газар дээр нь танилцан, санал бодлыг сонсож, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, нийгмийн даатгалын холбогдох хууль тогтоомжийн талаар зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Мөн 2025 оны 03 дугаар сарын 16-ны өдөр “Гэрээний залуусын нэгдэл” ТББ-аас зохион байгуулсан “Залуусын	100%

					хөдөлмөрийн гарц" уулзалтад оролцсон 38 иргэн, 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн Чонжү хотод гэрээт иргэдийн дунд зохион байгуулсан сагсан бөмбөгийн тэмцээнд оролцсон 19 иргэн, 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдөр Чонжү хотод зохион байгуулагдсан "Гэрээт иргэдийн намрын фестиваль"-д оролцсон 20 иргэн, нийт 77 гэрээт иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, санал хүсэлтийг сонсож ажиллав. Томилолтын зардал төсөвт тусгагдаагүйн улмаас ажлын байранд очиж төрийн үйлчилгээг үзүүлэхэд хүндрэлтэй байна.	
2.2	Хөдөлмөрийн гэрээний хугацаа дуусах дөхсөн хөдөлмөрийн гэрээт ажилчдад хугацаандаа нутаг буцахыг сануулсан мессеж илгээх, утсаар холбогдож сануулах арга хэмжээ авах	Мессежээр мэдээлэл хүргэсэн тоо: (500 хүн) Утсаар холбогдсон тоо: (60 хүн)	Хугацаандаа нутаг буцахыг зөвлөсөн масс мессежийг 568 иргэнд 3 удаагийн давтамжтай илгээж, 73 иргэнтэй утсаар холбогдож зөвлөгөө мэдээлэл хүргэсэн.	Хууль бусаар оршин суухын хор уршгийг таниулж, мэдээлэл хүргэнэ.	Тасгийн ажилтнуудад хөдөлмөрийн гэрээт ажилчдыг бүс нутгаар хуваарилан хариуцуулж гэрээний хугацаа дуусаж нутаг буцах дөхсөн иргэдтэй утсаар холбогдон тулгамдсан асуудал, санал хүсэлтийг нь сонсож, хууль бусаар оршин суухаас сэргийлэх, хугацаандаа нутаг буцахыг зөвлөх, масс мессеж илгээх зэргээр давхардсан тоогоор нийт 1796 (утас-372, масс мессеж-1424) гэрээт иргэнд мэдээлэл хүргэсэн.	100%
2.3	Тус төвд хандаж нутаг буцах гэрээт иргэдийн мэдээллийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт тогтмол хүргүүлэх	Мэдээлэл хүргэх тоо: (Жилд 2 удаа)	БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр Монгол Улсын 2144 иргэн ажиллаж байна. 2024 онд тус төвд хандаж 55 иргэн нутаг буцаж, 30.2 сая.воны буцах замын зардлыг олгуулсан.	ХХҮЕГ-т тус төвд хандаж нутаг буцаж буй гэрээт иргэдийн мэдээллийг хүргүүлж ажиллана.	БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаад нутаг буцаж буй иргэдэд харьяа яам болон ХХҮЕГ-ын Дэмжих сангийн төсөл хөтөлбөрийг сурталчлах ажлын хүрээнд "2025 онд нутаг буцсан иргэдийн мэдээллийн сан"-г үүсгэсэн ба 124 иргэний мэдээллийг бүртгэсэн. Судалгааг гаргаж 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр 1/79 албан тоотой ХХҮЕГ-т хүргүүлсэн. Мэдээллийн санг тогтмол шинэчилж нутаг буцсан иргэдийн мэдээллийг сар бүрийн 05-ны өдөр ХХҮЕГ-т цахимаар илгээж хэвшсэн.	100%

2.4	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаад нутаг буцаж буй иргэдэд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг хүргэх, сурталчлах		Мэдээлэл хүргэсэн иргэний тоо: (30 хүн)	Анх удаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	Эх орондоо эргэн суурьшсаны дараа хамрагдах боломжтой төсөл хөтөлбөр, бичил бизнесийн талаарх мэдээллийг харьяа яам, агентлагтай хамтран сурталчилна.	БНСУ-д хөдөлмөр эрхлээд нутаг буцаж буй Монгол иргэдийг эх орондоо бизнес эрхлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор БНСУ-ын “The Bridge International” байгууллагатай хамтран судалгаа хийж 57 иргэнийг хамруулан судалгааны үр дүнг 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр ГБХНХЯ-нд илгээсэн. Хугацаа дуусан нутаг буцах дөхөж буй 300 иргэн рүү масс мессеж илгээн төслийн судалгаанд хамрагдах талаар мэдээлэл хүргэсэн. ХХҮЕГ-аас нутаг буцаж буй гэрээт иргэдийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хамруулах боломжийг судалж санал хүргүүлэх үүрэг өгсний дагуу санамсаргүй түүврийн аргаар 5 иргэн сонгож хувийн мэдээллийг хавсарган ХХҮЕГ-т хүргүүлсэн. БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яамны харьяа Гадаад ажилчдыг дэмжих сангаас хэрэгжүүлж буй “Хөдөлмөрийн гэрээ дуусгавар болж Солонгос улсаас эх орондоо буцаж буй иргэдийг нэгтгэх ODA төсөл”-ийн судалгааг 60 иргэнээс авч үр дүнг нэгтгэсэн. 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр "Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай" хуульд заасан гадаадад ажиллаж байгаад эх орондоо буцаж ирэхэд дэмжлэг үзүүлэх зохицуулалтын талаар байгууллагын цахим хуудсаар сурталчлан танилцуулав.	100%
Зорилт 3. БНСУ-д оршин сууж байгаа Монгол иргэд, гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх арга хэмжээ							
3.1	БНСУ-д амьдарч буй Гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, олон соёлт гэр бүлийн судалгааг тогтмол шинэчилж,		Мэдээллийн сангийн шинэчлэлт: (Жилд 2 удаа)	БНСУ-д оршин сууж буй олон соёлт гэр бүлийн статистик, визний ангилал, хүүхдийн тоо, нас, хүйс оршин суугаа	БНСУ-д амьдарч буй гэр бүл, хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хууль, эрх зүйн мэдээллээр	БНСУ-ын статистикийн тайланг үндэслэн тухай бүр Олон соёлт гэр бүлийн мэдээллийн санг баяжуулсан. БНСУ-д эмчилгээний болон бусад визтэй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг	100%

	зорилтот арга хэмжээг зохион байгуулж, зөвлөгөө мэдээлэл өгөх		Зорилтот арга хэмжээний тоо: (4 удаагийн арга хэмжээ) Арга хэмжээнд оролцох иргэний тоо: (400 хүн) Зөвлөгөө, мэдээлэл өгөх иргэний тоо: (40 хүн)	байршлын мэдээллийг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн мэдээллийн сан үүсгэсэн. Гэр бүл, хүүхэд, нийгмийн хамгааллын хууль тогтоомжийг сурталчлах, зорилтот бүлэгт зөвлөгөө мэдээллийг хүргэх чиглэлд 5 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, 584 иргэн хамрагдсан.	хангаж, мэдээллийн санг тогтмол баяжуулна.	эх 31 иргэнийг нэгтгэсэн "자폐 맘스" фэйсбүүк групп үүсгэн мэдээлэл солилцон ажиллаж байна. Зорилтот дараах арга хэмжээг зохион байгуулж нийт 294 иргэнийг хамруулав. Үүнд: - БНСУ-ын Улсан хот дахь "КИМС хүүхэд хөгжлийн мэргэшсэн төв"-тэй хамтран ажиллах хүрээнд тус төвийн эмчтэй хамтран 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 15-ны өдрийн хооронд Улаанбаатар хотын 10 дугаар цэцэрлэгийн 22, 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Сөүл хотноо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг эхэд зориулсан сургалтыг 16 хүүхэд, эцэг, эхэд зохион байгуулав. - 2025 оны 07 дугаар сарын 13-ны өдөр Пажү хотын наадамд "Уран уншигч хүүхэд" шүлгийн уралдаанд 7 хүүхэд, "Шагайн наадгай" морин уралдаанд 40 гаруй хүүхэд, "Эмэгтэйчүүдийн шагайн харваа"-нд 30 гаруй эмэгтэйг оролцуулсан арга хэмжээг зохион байгуулав. - "Монгол хэл бичгийн төв" ТББ-тай хамтран эх хэлээ сурахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор өөрийн төвийн байранд 40 хүүхдийг "Монгол хэл бичгийн сургалт"-д ням гараг бүр хамруулсан. - 2025 оны 05 дугаар сард 13-16 насны хүүхдүүдэд зориулсан сэтгэл зүйн бүлгийн сургалтыг Сөүл хотын Добонгу дүүргийн гэр бүлийн төвтэй хамтран зохион байгуулж 12 гэр бүлийн 24 иргэнийг хамруулсан. - Чөлөөт уран бүтээлч А.Навчаатай хамтран "Хуримын зургийн эвент" арга хэмжээг 2025 оны 07 дугаар сарын 15-
--	---	--	--	--	--	---

					наас зохион байгуулж 14 гэр бүл, 28 иргэнийг хамруулсан. - 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр БНСУ дахь Монгол сургуулийн бага ангийн 75 сурагчид дэлгэцийн хамаарал сэдвээр, 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдөр Мёнил бага сургуулийн 14 сурагчид сэтгэлзүйн сургалт зохион байгуулсан. 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр Монгол таун орчимд гэр бүл, хөгжлийн бэрхшээлтэй иргэний дэмжлэг, хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал сэдвээр явуулын үйлчилгээ зохион байгуулж 104 иргэнийг хамруулав. ГБХНХЯ-ны захиалгаар хийгдсэн “Хилийн чанад дахь Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал, өөрчлөлт” судалгааны хамрагдалтад дэмжлэг үзүүлж, нийт 110 иргэнийг судалгаанд хамруулсан.	
3.2	Монгол үндэстний баяр ёслол, тэмдэглэлт өдрөөр үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Дээлтэй Монгол” арга хэмжээг зохион байгуулах	Арга хэмжээнд хамрагдах иргэдийн тоо: (100 хүн)	Анх удаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	Өөрийн болон суугаа орны иргэдэд Монгол өв соёл болоод төвийнхөө үйл ажиллагааг сурталчилж, төрийн үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллана.	2025 оны 07 дугаар сарын 12-ны өдөр БНСУ-ын өмнөд бүсийн Пусан хотын “Монголоороо гоёцгооё” наадмын үеэр уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, угсаатны дээл хувцас, эд хэрэглэл, соёлын биет бус өвийг сурталчлах зорилгоор “Дээлтэй Монгол” уралдааныг Пусан хотод суугаа Консулын газартай хамтран зохион байгуулж, өмнөд бүсийн 9 хотын дээлтэй монгол оролцогчдоос шалгарсан Кимхе хотын оролцогчдыг шилжин явах цомоор шагнав.	100%
3.3	БНСУ-д амьдарч байгаа хүүхдүүдийн дунд эх орон, тусгаар тогтнол, түүх, соёл, ёс заншлыг таниулах зорилгоор “Уншдаг хүүхэд хөгждөг”	Арга хэмжээнд хамрагдах хүүхдийн тоо: (50 хүүхэд)	Анх удаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	БНСУ-д амьдардаг гэр бүл, хүүхэд багачуудад Монгол өв соёл, хэл, түүх, ёс заншлыг ойртуулан сурталчилж, хүүхэд, гэр бүлд чиглэсэн	2025 оны 07 дугаар сарын 13-ны өдөр Пажү хотод зохион байгуулагдсан наадамд “Уран уншигч хүүхэд” шүлгийн уралдааныг бага, дунд насны ангиллаар зохион байгуулж, 7 хүүхэд наадамчин олонд шүлгээ уншиж хүргэсэн ба	90%

	өдөрлөг, насны ангиллаар шүлэг найраглалын тэмцээн зохион байгуулах		Зөвлөгөө мэдээлэл өгөх иргэний тоо: (10 эцэг эх, хүүхэд)		үйлчилгээ, зөвлөгөө мэдээллийг хүргэж ажиллана.	хүүхдүүдийг байгууллагын талархлын бичиг, үнэ бүхий зүйлээр шагнав. “Монгол хэл бичгийн төв” ТББ-тай хамтран Монгол-Солонгос хос хэлний уралдаан, “Уран жиргээ” шүлгийн уралдааныг 2025 оны 12 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажил хангагдсан.	
3.4	Төвд хандсан Монгол Улсын иргэдэд (БНСУ-д ажиллаж, амьдарч байгаа хөдөлмөрийн гэрээт ажилчид, гэр бүл, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд) сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх		Зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлэх иргэний тоо: (250 хүн)	247 иргэнд сэтгэл зүйн тусламж үйлчилгээ үзүүлсэн (ганцаарчилсан сэтгэл засалд 207, бүлгийн сэтгэл засалд 40 иргэн хамрагдсан).	Үйлчлүүлэгчийн сэтгэц, зан үйлийн төлөв байдлыг үнэлж, оношлох, зөвлөгөө өгч, анхан шатны сэтгэц заслын үйлчилгээ үзүүлнэ.	Сэтгэл зүйн тулгамдсан асуудлаар зөвлөгөө, үйлчилгээ авахаар тус төвд хандсан БНСУ-д оршин суугаа Монгол Улсын 253 иргэнд ганцаарчилсан сэтгэл заслын үйлчилгээ үзүүлсэн. Сэтгэл зүйн байдлыг илрүүлэх зан төлөвийг үнэлэх зорилгоор хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар шинээр ирсэн 447 иргэнд нойрны өөрчлөлт, сэтгэл гутрал болон сэтгэл түгшилтийг илрүүлэх сорил хийж, үр дүнд үндэслэн судалгааны дүгнэлт гаргасан. Сэтгэл зүйн сургалтыг цахимаар болон танхимаар мэргэжлийн байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулж, “Ажил амьдралын тэнцвэр”, “Өсвөр насны сэтгэл зүйн онцлог”, “Нойрны чанар ба амьдралын хэв маяг”, “Ядаргааг дусал тариагаар эмчилдэг үү”, “Гэр бүлийн харилцааны үнэт зүйл ба хамтын сэтгэлзүй”, “Шилжилт хөдөлгөөн ба сэтгэлзүйн эрүүл мэнд”, “Стресс биед хэрхэн нөлөөлдөг вэ”, “Ганцаардал уу эсвэл сэтгэл гутрал уу”, “Монгол Улсад байр авахад анхаарах зүйл” нийт 9 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж 213 оролцогчийг хамруулав. Танхимаар “Дэлгэцийн хамаарал” сэдэвт сургалтыг Сөүл хот дахь Монгол сургуулийн 75 сурагчид, Кимс төвийн тэргүүн Ким Гён Мин профессортой хамтран сэтгэл зүйн сургалтыг тусгай	100%

					хэрэгцээт хүүхэдтэй 16 эцэг эхэд, БНСУ-ын Мөнил бага сургуулийн 14 сурагчид сэтгэлзүйн сургалтыг зохион байгуулж, картын арга болон зургийн аргыг ашиглаж сэтгэлзүйн байдалд үнэлэлт дүгнэлт өгсөн. Түүнчлэн “Гэрээний залуусын нэгдэл” ТББ, Awezone page, Utransfer мөнгө гуйвуулгын газар, БНСУ дахь Оюутны холбоо зэрэг байгууллагын урилгаар подкаст ярилцлагад оролцож, сэтгэл зүйн зөвлөгөө өгсөн.		
3.5	БНСУ-д оршин суугаа Монгол Улсын иргэдэд нийгмийн хамгааллын тусламж, үйлчилгээ үзүүлэх		Эрүүл мэндийн үйлчилгээ авах иргэний тоо: (50 хүн)	Анх удаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	Эрүүл мэндийн даатгалд хамрагдах боломжгүй иргэдийг даатгалд хамруулж, эрүүл мэндийн үйлчилгээ авахад нь дэмжлэг үзүүлж ажиллана.	Нийгмийн хамгааллын үйлчилгээний хүрээнд эрүүл мэндийн үзлэг оношилгоог нийт 13 удаа зохион байгуулж, 153 иргэнийг хамруулан, орчуулгын туслалцаа үзүүлж, 12,640,000 воны эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үнэ төлбөргүй авахад дэмжлэг үзүүлэв. Үүнд: -БНСУ-ын эмнэлгүүдийн “Хинён” эрүүл мэндийн хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх нийгэмлэгтэй хамтран 10 удаагийн арга хэмжээгээр визгүй 57, Е-9 визтэй 8 иргэнд 5,540,000 воны эрүүл мэндийн үйлчилгээ; -БНСУ-ын 행동하는의사회 буюу “Doctor’s action for health” байгууллагатай хамтран 3 удаагийн арга хэмжээгээр визгүй 88 иргэнд 6,345,000 воны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хөнгөлөлт үзүүлсэн.	100%

ХОЁР. НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Зорилт 4. БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа болон бусад хөдөлмөрийн гэрээнээс бусад хэлбэрээр ажиллаж, амьдарч байгаа иргэдийг Монгол Улсын нийгмийн даатгалд албан журмаар болон сайн дураар хамруулах арга хэмжээ

4.1	БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэдийг Монгол Улсын		Даатгуулагчийн тоо: (1884 иргэн)	2024 оны жилийн эцсийн байдлаар тэтгэврийн даатгалд	БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ирж байгаа иргэд, ажил	НДЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалын дагуу 2025 онд нийт 671 иргэнийг шинээр	44%
-----	---	--	----------------------------------	---	---	---	-----

	нийгмийн даатгалын тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулах			албан журмаар 1213 иргэн хамрагдсан.	олгогчдод холбогдох хууль тогтоомжийг танилцуулан гэрээ байгуулж, даатгалд хамруулна.	хамруулах төлөвлөгөөтэй. Тайлант хугацаанд БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн 535 иргэнд нийгмийн хамгааллын хэлэлцээрийг сурталчлан танилцуулж, ажил олгогчдод албан бичиг, зөвлөмжийг хүргүүлж, гэрээ байгуулан нийт 295 буюу 55.1%-ийг тэтгэврийн даатгалд албан журмаар хамруулсан. Гүйцэтгэл 43,9 хувь Хөдөлмөрийн гэрээ дууссан, хууль бус болсон, ҮТА-д шимтгэл төлсөн болон бусад шалтгааны улмаас 106 даатгуулагч даатгалаа зогсоосон байна. 2025 оны албан журмын даатгуулагчийн суурь түвшин 1213 бөгөөд 2025 оны 11 сарын дүнгээр 1402-т хүрсэн байна. 2025 онд Монголоос 1000 ажилтан ирэх квоттой байснаас 53.5% буюу 535 ажилтан ирсэн байна. Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 216 даатгуулагчид шинээр, 312 хугацаа сунгасан, 81 ажлын байраа сольсон зэрэг шалтгаанаар Монгол Улсын нийгмийн даатгалд хамрагдсан гэрчилгээг нийт 609 олгосон.	
4.2	БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн визний ангиллаар оршин сууж буй Монгол Улсын иргэдийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хамруулах	Даатгуулагчийн тоо: (1625 иргэн) Хүсэлт гаргасан даатгуулагч бүрд гэрчилгээг 100% олгоно.	2024 оны жилийн эцсийн байдлаар сайн дурын даатгалд 1122 иргэн хамрагдсан.	БНСУ-д Е-9-өөс бусад визээр оршин суугаа Монгол Улсын иргэдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, даатгалд хамруулна.	НДЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/10 дугаар тушаалын дагуу 2025 онд нийт 503 иргэнийг шинээр хамруулах төлөвлөгөөтэй. БНСУ-д хөдөлмөрийн гэрээнээс бусад хэлбэрээр оршин суугаа 316 иргэнийг даатгалд хамруулж, гэрээ байгуулж, нийгмийн даатгалд хамруулсан. Гүйцэтгэл 62,8 хувь Тэтгэвэрт гарсан, Монгол буцсан, өөрийн хүсэлтээр цуцалсан болон бусад шалтгааны улмаас нийт 133 даатгуулагч гэрээгээ цуцалсан.	63%	

						2025 оны сайн дурын даатгуулагчийн суурь түвшин 1122 бөгөөд 2025 оны 11 сарын дүнгээр 1305-д хүрсэн байна. Монгол Улс, БНСУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу 287 даатгуулагчид шинээр, 206 хугацаа сунгасан, 74 ажил сольсон зэрэг шалтгаанаар Монгол Улсын нийгмийн даатгалд хамрагдсан гэрчилгээг 567 олгосон.	
Зорилт 5. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, тайлагнах арга хэмжээ							
5.1	Нийгмийн даатгалын сангийн жилийн орлогын төлөвлөгөөг биелүүлж, нийгмийн даатгалын санг бүрдүүлэх		Сангийн орлогын төлөвлөгөө: 5,031,742,000 төгрөг	2024 оны жилийн эцсийн байдлаар санд 3,071,975,506.7 төгрөгийн орлого төвлөрүүлсэн.	БНСУ-ын ажил олгогч, гэрээт ажилтан, сайн дурын даатгуулагчдаас хууль тогтоомжид заасан дүнгээр БНСУ-ын 4 банк, ХААН банкаар дамжуулан даатгалын шимтгэлийн орлогыг холбогдох санд төвлөрүүлнэ.	2025 оны 11 сарын байдлаар нийгмийн даатгалын санд 2,641,222,769,72 төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд гүйцэтгэл 52,4% байна. Нийт 770 даатгуулагчийн 3357 сарын 466,168,908 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулсан. Даатгуулагчийн шимтгэлийг хугацаанд төлүүлэхийн тулд 1583 нэхэмжлэхийг ажил олгогчид хүргүүлж, даатгуулагчидтай 4276 удаа утсаар холбогдож, нийт 1237 даатгуулагчид масс мессэж илгээсэн. Дор дурдсан шалтгааны улмаас сангийн төлөвлөгөө тасалдаж байна. Үүнд: • БНСУ-ын “Үндэсний тэтгэврийн даатгалын тухай” хуулийн 127 дугаар зүйлд зааснаар тухайн улсад ажил, хөдөлмөр эрхлээд Үндэсний тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлээ /ажил олгогч 4,5%, даатгуулагч 4,5%/ нутаг буцахдаа нэг удаа 100% буцаан авдаг тул манай гэрээт ажилтнууд өөрийн улсын нийгмийн даатгалд даатгуулдаггүй. • 2024, 2025 онд тус тасгийн нийгмийн даатгалын сангийн төлөвлөгөөг өмнөх онуудаас 66.9%-иар огцом нэмэгдүүлсэн. • 2025 оны гэрээт ажилтны квот ашиглалт 53.5% байсан.	52,4%

						• Тасгийн хүний нөөц тогтворгүй, үндсэндээ хагас жилээс хойш 5 хүнтэй ажилласан. • Төвийн шатахуун, томилолтын зардал хангалтгүйгээс явуулын үйлчилгээ багассан. • Иргэд тогтвор суурьшилгүй, шилжилт хөдөлгөөн их, утасны дугаараа байнга сольдог.	
5.2	Сангийн мэдээ, тайланг хуулийн хугацаанд гаргаж, хүргүүлэх		Сангийн мэдээ, тайлан: (жилд, мэдээг 12 удаа, тайланг 4 удаа)	2024 онд сангийн мэдээг 12 удаа, тайланг 4 удаа гаргаж хүргүүлсэн. Шилэн дансанд 4 удаа мэдээ байршуулсан.	Сар бүр сангийн мэдээг гаргаж НДЕГ-т илгээнэ. Улирал бүр сангийн тайланг гаргаж НДЕГ-т илгээнэ. Сар бүр сангийн мэдээний холбогдох тоо баримтыг Шилэн дансанд байршуулна.	БНСУ-ын 3 банканд төвлөрүүлсэн албан журмын даатгалын шимтгэлийн орлогыг НДЕГ-ын Төрийн банкны харилцах дансанд сар бүрийн 25-ны өдөр, сайн дурын даатгалын шимтгэлийг “Хаан” банкны холбогдох дансаар өдөр бүр шилжүүлж, нийт 11 удаагийн сарын мэдээг “Sicos” программаар боловсруулан НДЕГ-ын Санхүү, хөрөнгө оруулалтын газарт тайлагнасан. Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг 11 удаа байршуулсан.	100%

ГУРАВ. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

Зорилт 6. БНСУ-д амьдарч буй иргэд болон хөдөлмөрийн гэрээт иргэдэд сургалт, сурталчилгаа зохион байгуулах, гадаад хамтын ажиллагаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1	БНСУ-д 2025 онд хөдөлмөрийн гэрээгээр ирж ажиллах ажилчдыг ирэхийн өмнөх цахим сургалт, ирсний дараах танхимын сургалтад хамруулах		Ирэхийн өмнөх сургалт Ирсний дараах сургалт Сургалтад хамруулсан гэрээт ажилчны тоо	2024 онд ирэхээс өмнөх 14 удаагийн сургалтад 456 иргэнийг, ирсний дараах 12 удаагийн сургалтад 395 иргэнийг, нийт 26 удаагийн сургалтад давхардсан тоогоор 851 хөдөлмөрийн гэрээт ажилчныг хамруулсан.	Хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирсэн иргэдийг 100% сургалтад хамруулна.	БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар ирэх 420 иргэнд ирэхээс өмнөх сургалтыг 10 удаа цахимаар зохион байгуулсан бол ирсний дараах 17 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 535 хөдөлмөрийн гэрээт ажилчныг хамруулан БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төв, Инчеон, Ичон дахь сургалтын төвүүдэд зохион байгуулав. Сургалтаар хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс тооцох, ажлын байр солих,	100%
-----	--	--	---	--	---	--	------

						хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, давтан болон тогтвортой нөхцөлөөр дахин ирж ажиллах, ур чадвартай ажилчны E-7-4 виз рүү шилжих, суугаа орны онцлог, гэмт хэрэг, зөрчил, хууль бусаар оршин суухаас сэргийлэх, дасан зохицох сэтгэл зүй зэрэг асуудлаар мэдээлэл өгсөн. Сургалтын агуулга, хүртээмжийг сайжруулах зорилгоор Ёжү хот дахь сургалтын төвд санал тавьж сургалтын хугацааг 50 минут болгон уртасгасан. Сэрээт машин жолоодох эрх олгох сургалтыг БНСУ-ын Хөдөлмөр, нийгмийн үйлчилгээний сургалтын төв ТББ-тай хамтран зохион байгуулж, 21 гэрээт иргэнийг хамруулсан.	
6.2	“Явуулын үйлчилгээ” зохион байгуулах		Зохион байгуулах арга хэмжээний тоо: (6) Үйлчилгээнд хамрагдах иргэний тоо: (500 хүн)	БНСУ-ын 16 муж, дүүрэг, хотод нийт 18 удаагийн явуулын үйлчилгээг зохион байгуулсан. 350 иргэнд нийгмийн даатгал, 486 иргэнд хөдөлмөрийн харилцаатай холбоотой үйлчилгээ үзүүлсэн.	Өөрийн болон суугаа орны хөдөлмөр, нийгмийн даатгал, гэр бүлийн талаарх хууль тогтоомжийг сурталчлан таниулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөвлөгөө мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай үзүүлж, ойртуулж ажиллана.	БНСУ-ын Гуанжү, Сөүл, Үжинбү, Мугпу, Улсан, Чонжү, Хунсон, Чонан, Инчон, Сувон, Илсан, Бусан, Чангвон, Шихин, Ансон, Жэжү хотод нийт 28 удаагийн явуулын үйлчилгээг Монгол Улсаас БНСУ-д суугаа ЭСЯ-ны Консулын хэлтэс, Бусан хотод суугаа Консулын газар, Төрийн банк, Хаан банк, Улсан хотын "КИМС" хүүхэд хөгжлийн мэргэшсэн төв, Үжинбү хотын Шинхан Их сургууль, “Гэрээний залуусын нэгдэл” ТББ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж, 418 иргэнд хөдөлмөрийн харилцаатай холбоотой, 365 иргэнд нийгмийн даатгалтай холбоотой үйлчилгээг газар дээр нь үзүүлэн, хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч, 1726 иргэнд гарын авлага, танилцуулга мэдээллийг хүргэсэн.	100%
6.3	Байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомжийг сурталчлах ажлыг		Бэлтгэж хүргэсэн мэдээллийн тоо:	Байгууллагын вэб сайтад 108 удаа, олон нийтийн цахим сүлжээнд 160 мэдээ,	Байгууллагын вэб болон social хуудас, олон нийтийн цахим сүлжээнд мэдээлэл	Төвийн “БНСУ дахь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төв” фэйсбүүк сошиал хуудсанд 272 удаа, байгууллагын https://seoulcenter.mlsp.gov.mn цахим	100%

	тогтмол, үр дүнтэй зохион байгуулах	(30 мэдээ, нийтлэл, ярилцлага) Чатбот автомат хариулагчаас мэдээлэл авсан иргэний тоо: (300 хүн)	нийтлэл, ярилцлага, видео, инфографикийг мэдээлсэн. Төвийн social хуудсанд 2024 оны 05 дугаар сараас чатбот холбож, тайлант хугацаанд 631 иргэн тус автомат хариулагчаас хэрэгцээт мэдээллээ авсан.	бэлтгэн нийтлэх, төвийн чатбот хариулагчаар мэдээллийг тус тус хүргэнэ.	хуудсанд 240 удаагийн хууль тогтоомж, мэдээлэл, зөвлөгөө нийтэлж 2,094,917 хандалт авсан. Чатбот холбон мэдээллийг 24/7 орон зай цаг хугацааны хязгаарлалтгүй хүргэж байгаа ба тайлант хугацаанд 1640 иргэн автомат хариулагчаас мэдээлэл авсан. Хөдөлмөрийн гэрээт иргэдэд зориулсан хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгал, БНСУ-ын хууль тогтоомжийн мэдээллийг агуулсан гарын авлага бэлтгэж 500 ширхгийг хэвлүүлэн тараан ажиллаж байна. Мөн хөдөлмөрийн харилцаа, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлан таниулах зорилгоор дараах ажлыг зохион байгуулсан. Үүнд: - 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдөр “Гэрээт иргэдийн хөдөлмөрийн харилцаанд тулгарч буй асуудал” сэдвийн хүрээнд “Ур чадвартай ажилчны E-7-4 виз”, “Ажлын байр солих тогтолцооны дагуу ажлын байр солихтой холбоотой асуудлыг судлан шийдвэрлэх аргачлал” цахим уулзалт, - 2025 оны 08 дугаар сарын 03-ны өдөр “Олгогдоогүй цалин хөлсний маргаан, 13 дахь сарын цалин бодох аргачлал” сэдэвт цахим уулзалт, - 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдөр нийгмийн даатгалын цахим сургалт, - 2025 оны 08 дугаар сарын 17-ны өдөр “Нийгмийн даатгалын ач холбогдол”-ын талаарх цахим сургалт, - 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр “Нийгмийн даатгалд сайн дураар хэрхэн хамрагдах тухай” сэдвээр цахим сургалт. Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдлыг сурталчлах зорилгоор биечлэн ирсэн 480 иргэн, утсаар 3,531,	
--	--	--	---	--	---	--

						цахимаар /чат-бот/ 101 нийт 4112 иргэнд мэдээлэл зөвлөгөө өгч ажилласан байна.	
6.4	Монгол Улс болон БНСУ-д үйл ажиллагаа явуулдаг төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах		Хамтран ажиллах байгууллагын тоо: (8) Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо: (8)	2024 онд БНСУ-ын төрийн болон төрийн бус байгууллага, тус улсад үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын төр, хувийн хэвшлийн нийт 10 байгууллагатай хамтран ажилласан.	Төвийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, БНСУ-д ажиллаж амьдардаг Монгол Улсын иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалахын төлөө ажиллана.	2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр БНСУ-ын Улсан хот дахь “КИМС хүүхэд хөгжлийн мэргэшсэн төв”-тэй хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. 2025 онд тус төвөөс БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэрэг эрхлэх газар, Сөүл хотын Хөдөлмөр, халамжийн төв, Гёнгү аймгийн өргөмжит консул, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлтийн хөгжлийн сангийн Ёжү хот дахь Олон улсын сургалтын төв, Инчеон, Ичон дахь сургалтын төв, “Jubilee” эрүүл мэндийн нийгэмлэг, Олон улсын боловсрол солилцооны нийгэмлэг, Солонгос дахь Монгол сургууль, Инха, Юхан Их сургууль, “Гэрээний залуусын нэгдэл” ТББ зэрэг нийт 25 байгууллагатай хамтран ажиллаж байна. Хамтын ажиллагааны хүрээнд холбогдох уулзалтыг зохион байгуулж хамтран ажиллахаар тохиролцов. Тухайлбал, - 2025 оны 03 дугаар сарын 18-нд "Солонгосын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын төв" сургалтын байгууллагын удирдлагатай гадаад ажилчдыг ахисан түвшинд хүргэх мэргэшүүлэх сертификат олгох асуудлаар; - 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр БНСУ-ын “The Bridge” байгууллагатай БНСУ-д хөдөлмөр эрхлээд нутаг буцаж буй Монгол иргэдийг (Е-9, Е-7) эх орондоо бизнес эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр; - 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр KASMI буюу БНСУ-ын Жижиг дунд үйлдвэрийн хөгжлийн холбооны Гадаад ажиллах хүчийг дэмжих газартай	100%

					хөдөлмөрийн гэрээт ажилчны Е-7-4 виз рүү сольсон иргэдийг ажлын байранд зуучлах асуудлаар; - 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдөр “Гадаад ажилчдын хүний эрхийн төв” ТББ-ын төлөөлөлтэй уулзаж БНСУ-д оршин сууж буй гадаад хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хамгаалах хүрээнд эрх зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр; - 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр БНСУ дахь Улаан загалмай нийгэмлэгийн Олон улсын хамтын ажиллагааны хэлтсийн даргатай уулзалт зохион байгуулж иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр. Тус төвөөс дараах албан томилолт, уулзалтыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллав. Үүнд: - 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс 07-ны өдрүүдэд Сөүл хотноо ажилласан ГБХНХЯ, ХХҮЕГ-ийн төлөөлөгч нарын албан томилолт; - 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 04-ний өдрүүдэд ажилласан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн гишүүд болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан хаагчдын албан томилолт.	
Зорилт 7. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийг чадавхжуулах, төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга хэмжээ						
7.1	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд батлагдсан загварын дагуу боловсруулж, батлуулах, үйл ажиллагааг зохион байгуулах	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө: 1 Хэрэгжилтийн тайлан: 2	2024 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайланг холбогдох журмын дагуу боловсруулж тайлагнасан.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хэрэгжилтийг хагас жил, жилийн эцсээр тайлагнана.	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулан, хуулийн хугацаанд батлуулсан. 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн тайланг боловсруулж, заасан хугацаанд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлсэн.	100%

7.2	Төрийн албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр сургалтад хамруулах		Зохион байгуулсан сургалтын тоо: (3) Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо: (24 хүн)	БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэрэг эрхлэх газрын аюулгүй ажиллагааны туршлага судлах сургалт (2024.06.11); БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн боловсролын институтын мэргэшүүлэх сургалт (2024.11.08); Удирдлагын академийн "Төрийн албан хаагчийг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх" сургалт (2024.12.02);	Төрийн албан хаагчдыг чадавхжуулах чиглэлээр сургалт зохион байгуулж, нийт албан хаагчдаа хамруулна.	Монгол Улс, БНСУ-ын төрийн байгууллагаас зохион байгуулсан 15 удаагийн сургалтад төвийн 24 албан хаагч хамрагдсан. Үүнд: - БНСУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэрэг эрхлэх газрын аюулгүй ажиллагааны туршлага судлах сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр; - Сөүл хотын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн хэлтсийн "Ажлын байр солиход анхаарах асуудал сургалт-уулзалт"-д 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр - Авлигатай тэмцэх газрын "Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт"-д 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр; - НДЕГ-ын даргын баталсан төлөвлөгөөний дагуу 9,10,11 саруудад мэргэжилтнүүдийг чадавхжуулах 11 удаагийн сургалт, - Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас зохион байгуулсан "Нийгмийн халамжийн сургалт"-д 2025 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр. Мөн Төрийн албаны зөвлөлийн "7:4:10" 12 удаагийн цахим сургалтад хамрагдсан. Албан хаагчид дотооддоо "БНСУ-ын Хөдөлмөрийн суурь хууль", Хувь хүний хөгжил, Нийгмийн даатгалын ач холбогдол зэрэг нийт 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан.	100%
7.3	"Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор төвийн албан хаагчдад үндэсний монгол бичгийн сургалтыг зохион байгуулах		Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо: (24 ажилтан)	Анх удаа зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	2025.01.01-ний өдрөөс эхлэн "Төрийн байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах" Монгол хэлний тухай	Нийгмийн даатгалын ерөнхий газрын сургалтын Динамик платформоос Монгол бичгийн анхан болон дунд шатны гарын авлагыг татан авч төвийн албан хаагчдад 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хүргүүлэн суралцах чиглэл өгсний дагуу албан хаагчид бие даан суралцаж байна.	90%

					хуулийн заалтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах зорилгоор сургалт зохион байгуулна.		
7.4	Төвд ирүүлсэн иргэд, ажил олгогч, даатгуулагчаас ирсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх		Хүсэлтийн тоо: Өргөдөл гомдлын тоо: Шийдвэрлэлтийн хувь:	Нийгмийн даатгалтай холбоотой 102, хөдөлмөрийн харилцаатай холбоотой 187, бусад 12 өргөдөл, хүсэлт ирснийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.	Төвд ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажиллана.	Төвд иргэдээс ирүүлсэн 5 өргөдөл (хүсэлт)-ийг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажилласан. Хөдөлмөрийн харилцаанд тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэхээр хандсан 394 иргэний өргөдөл, гомдлыг хүлээн авч, БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам, ажил олгогч эзэд болон холбогдох бусад байгууллагуудтай харилцан зөвшилцөх, эвлэрүүлэн зуучлах, гомдол барагдуулах, орчуулга хийх, зардал төлбөр олгуулах зэргээр өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. Иргэд даатгуулагчдаас ирсэн 1,874 хүсэлт, 13 өргөдлийг бүрэн шийдвэрлэсэн. Үүнд: - БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалаас чөлөөлөгдөх гэрчилгээ авах хүсэлт 1176, - Нийгмийн даатгалын мэдээллийн сангаас лавлагаа авах хүсэлт 576, - Нийгмийн даатгалын аппликейшнд бүртгүүлэх хүсэлт 91, - Даатгуулагчийн тодорхойлолт, эмнэлгийн тодорхойлолтын орчуулга авах хүсэлт 31, - Илүү төлсөн шимтгэлээ буцаан авах өргөдөл 14 байна. - Мөн БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хугацаандаа БНСУ-ын Үндэсний тэтгэврийн даатгалд даатгуулаад нутаг буцсан, төлсөн шимтгэлээ буцааж авахаар ирүүлсэн 12 ээлжийн 48 иргэний 211,344,890.00 вон нэхэмжилсэн	100%

						хүсэлтийг холбогдох бичиг баримтын хамт тус улсын Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлж, 6 ээлжийн 25 иргэний 123,503,850.00 воныг буцаан олгуулсан.	
7.5	Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтад хамруулах, хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг хуулийн хугацаанд мэдүүлэх		Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо: (24 ажилтан) ХАСХОМ мэдүүлсэн албан хаагчийн тоо: (2)	“ХАСХОМ мэдүүлэх нь”, “Авлигын эсрэг” хоёр цахим сургалтыг зохион байгуулж, төвийн нийт албан хаагчид (22 хүн) хамрагдсан. 2 албан хаагч хуулийн хугацаанд ХАСХОМ мэдүүлсэн.	АТГ-тай хамтран нийт албан хаагчдад зориулсан сургалт зохион байгуулна. Холбогдох албан тушаалтнууд ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлнэ.	Авлигатай тэмцэх газраас “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтыг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан бөгөөд энэхүү сургалтад төвийн нийт албан хаагчид буюу 24 хүнийг хамруулсан. Мэдүүлэг гаргах үүрэг бүхий хоёр албан хаагч хуулийн хугацаанд ХАСХОМ мэдүүлсэн.	100%
7.6	Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн харилцаатай холбоотой суугаа орны хууль, эрх зүйн актуудыг орчуулж, албан хэрэгцээнд ашиглах		Орчуулсан баримт бичгийн тоо: (10)	Албан хэрэгцээнд ашигладаг хууль эрх зүйн зарим актуудын орчуулгыг шинэчлэх шаардлагатай.	Нэн шаардлагатай хууль, эрх зүйн акт, нэмэлт өөрчлөлтүүдийг орчуулж албан хэрэгцээнд ашиглана.	БНСУ-ын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр халамжийн харилцаанд холбогдох дараах 10 хууль тогтоомжийг орчуулсан. Үүнд: - Гадаадын ажилтны хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль - Бүтэн цагаар болон богино цагаар ажиллах ажилтныг хамгаалах тухай хууль - Иргэний насан туршийн мэргэжлийн чадварыг хөгжүүлэх тухай хууль - Мэргэжлийн ур чадварыг дэмжих тухай хууль - Жижиг дунд үйлдвэрийн ажиллах хүчийг дэмжих тусгай хууль - Үйлдвэрлэлийн ослын нөхөн төлбөрийн даатгалын тухай хууль - Ажил хайгчийн хөдөлмөр эрхлэлт болон амьжиргааны тогтвортой байдлыг дэмжих тухай хууль - Хөдөлмөрийн суурь хууль - Хөдөлмөрийн халамжийн суурь хууль - Мэргэжлийн тогтвортой байдлын тухай хууль	100%

						- Цалин нэхэмжлэх баталгааны тухай хууль - Үндэсний техникийн мэргэшлийн тухай хууль	
Зорилт 8. Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах арга хэмжээ							
8.1	Төвийн санхүү нягтлан бодох бүртгэлийг Олон улсын бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хүрээнд үнэн зөв бүртгэн хөтөлж, холбогдох мэдээ тайлан балансыг цаг хугацаанд нь гаргаж ажиллах		Санхүүгийн тайлан мэдээний тоо: (сарын мэдээ 12, улирлын тайлан 4, нэгдсэн тайлан 2)	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хуулийн дагуу тайланг хугацаанд үнэн зөв тайлагнаж (сарын мэдээ 12, улирлын тайлан 4, нэгдсэн тайлан 2) ажилласан.	Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлан мэдээг холбогдох хууль, журмын дагуу хугацаанд нь тайлагнана.	Нийгмийн даатгалын тасгийн 1 дүгээр улирлын санхүүгийн тайланг Green finance программаар гаргаж, НДЕГ-ын ахлах мэргэжилтэнд хүргүүлсэн. Төвийн 2,3 дугаар улирлын санхүүгийн тайланг labor.dynamic.mn программаар гаргаж Сангийн яамны Э тайланд баталгаажуулан ажиллаж байна.	100%
8.2	Төвийн үндсэн хөрөнгө, бараа, материалын тооцоо, тооллогыг хагас, бүтэн жилээр хийх		Хөрөнгийн тооллого: (жилд 2 удаа) Тайлан: (2 удаа)	Үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллогыг жилд 2 удаа хийж, мэдээ тайланг хугацаанд нь гаргаж ажилласан.	Үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллогыг хугацаанд нь хийнэ.	2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн А/23 дугаар тушаалаар 2025 оны эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 06 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 12-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн. 2024 оны жилийн эцсийн тайлангаар ашиглалтын хугацаа дуусаж элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 нэрийн тээврийн хэрэгсэл, 3 нэрийн компьютер тоног төхөөрөмжийг актлах саналыг 2025 оны 05 сарын 15-ны өдрийн 1/90 дугаар албан тоотойр ХХҮЕГ-д хүргүүлэн ажилласан байна. Мөн жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын ажлын хэсгийг төвийн даргын 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн А/43 дугаар тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан тооллогыг хийж гүйцэтгэв.	100%

8.3	Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах		Шилэн дансанд хугацаанд нь байршуулах мэдээллийн тоо: (171 мэдээлэл)	Шилэн дансны мэдээллийг хуулийн дагуу хугацаанд нь шивж, нийгмийн даатгал болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын тасгийн 171 мэдээллийг тус тус мэдээлсэн.	Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж, төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана.	Төвийн 2025 оны 01-11 дүгээр сарын санхүүгийн 171 мэдээллийг www.shilendans.gov.mn/ сайтад хуульд заасан хугацаанд байршуулсан.	100%
Дундаж үнэлгээ:							94.5%

Төлөвлөгөөг хянасан:

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч

..... 3.БАУЫРЖАН
(гарын үсэг)

(огноо)

Төлөвлөгөөг тайлагнасан:

БНСУ ДАХЬ ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ
(албан тушаал)

Тэмдэг

Төсвийн шууд захирагч

..... Б.ЖАРГАЛМАА
(гарын үсэг)

(огноо)